

АМАРЖИХ ГАЗРУУДЫН ЭРҮҮЛ АХУЙ, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2017 он

ЭМС-ИЙН 186,187,158, А/169 ТООТ ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ

АРИУТГАЛЫН ХЭСЭГ

ӨРГӨӨ АМАРЖИХ

ХҮРЭЭ АМАРЖИХ

АМГАЛАН АМАРЖИХ


Ариутгалын хэсэг 24 цагийн ажиллагаатай.

Ариутгалын 2 хэсэгтэй. "Бохир багаж, хэрэгслийг ариутгалын хэсэгт зөөвөрлөх журам"-ыг батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Вакуумдаж ариутгаж байгаа.



Ариутгалын 1 хэсэгтэй. Боолтын цаасаар боож, ариутгаж байна.



Ариутгалын 1 хэсэгтэй. Вакуум уут болон цаасаар боон ариутгаж байна.



БАГАЖИЙН АРИУТГАЛ

ӨРГӨӨ АМАРЖИХ

ХҮРЭЭ АМАРЖИХ

АМГАЛАН АМАРЖИХ

Амаржих газрууд уурын аритгалыг ашиглаж байна. Мөн Өргөө болон Амгалан амаржих этилийн оксидын ариутгалтай.



ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ

	Өргөө	Хүрээ	Амгалан
Гадаргуу	Жавелион	Incidin plus	Жавелион
Гар халдваргүйжүүлэгч	Aniosgel Manisoft	Manisoft	Aniosgel
Гарын шингэн саван	Aniossafe Skinman soft	Skinman soft	Skinman soft
Багаж ариутгал	Жавелион	Перкисс Skinsept cleaner	Хегзаниос
Салстын ариутгал	Skinsept F	Skinsept F	Skinsept F



Өргөө амаржих: Ариутгалын хэсэгт халдваргүйтгэлийн бодисын концентраци хэмжигч төхөөрөмж 2 ширхэгийг шинээр суурилуулсан.

ЗӨӨЛӨН ЭДЛЭЛИЙН АРИУТГАЛ

ӨРГӨӨ АМАРЖИХ

Зөөлөн эдлэлийг 2014 оноос эхлэн суурин дезкамерийн аппаратаар ажлын 5 хоногт хуваан хуваарь гарган ариутгаж байна.



ХҮРЭЭ АМАРЖИХ

Зөөлөн эдлэлийг “Ажин-Үжин” ХХК-тай гэрээ хийн хуваарийн дагуу тогтмол озоноор тогтмол халдваргүйжүүлж байна.



АМГАЛАН АМАРЖИХ

Зөөлөн эдлэлийг “Ажин-Үжин” ХХК-тай гэрээ хийн хуваарийн дагуу тогтмол озоноор тогтмол халдваргүйжүүлж байна.

ӨРГӨӨ АМАРЖИХ


Тасаг, нэгж бүр өртөлтийн дараах иж бүрдэлтэй. Мөн бүртгэлийг тухай бүр хийж ажиллаж байна. Цус, биологийн шингэн асгарсан тохиолдолд халдваргүйтгэж цэвэрлэх иж бүрдлийг тасаг, нэгж бүрт байршуулсан.



ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БАЙДАЛ

ӨРГӨӨ АМАРЖИХ

Цэвэрлэгээ үйлчилгээнд 2 хувингийн аргыг шинээр нэвтрүүлсэн. Мөн цэвэрлэгээ хийж буй үед халтирахаас болгоомжилсон тэмдэглэгээтэй болсон. Тоног, төхөөрөмжийг халдваргүйжүүлэх тусгай өрөөг тохижуулан, ажиллаж байна.



ХҮРЭЭ АМАРЖИХ

Цэвэрлэгээ үед халтирахаас болгоомжлуулсан тэмдэглэгээг тогтмол ашиглаж байна.

Цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэж буй алчууруудыг тушаалын дагуу тэмдэглэгээ хийн хэрэглэж байгаа.

Байгууллагын байр жижиг тул цэвэрлэгээний тэргэнцэр ашиглах боломжгүй.



АМГАЛАН АМАРЖИХ

Амаржих газрын даргын 2017 оны А/06 тоот "Цэвэрлэгээ хийх журам"-ыг боловсруулан гаргаж хэрэгжүүлсэн. Тасаг, хэсэг бүрт

- ✓ Цэвэрлэгээний тэргэнцэр
- ✓ Шал угаагч хувин
- ✓ Цэвэрлэгээний 4 өнгийн алчуур



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

ӨРГӨӨ АМАРЖИХ

Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нь халдвартай хог эмнэлэг доторх түр хадгалах цэгт хүргэдэг.

Бактериологи лабораториос гарч буй хог хаягдлыг устгалын автоклавт /121°C-т/ 50-60 минут халдваргүйжүүлсний дараа улаан өнгийн уутанд хийн, түр хадгалах байр руу зөөвөрлөдөг.



ХҮРЭЭ АМАРЖИХ

Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нь халдвартай хог хаягдлыг зориулалтын саванд хийн, маршрутын дагуу, хуваарьт заасан цагт түр хадгалах цэгт хүргэдэг.



АМГАЛАН АМАРЖИХ

Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нь эмнэлэг доторх түр хадгалах цэгт хүргэж, туслан ажилтанд жинлэн хүлээлгэн өгч хэвшсэн.



"Элемент" ХХК-тай жил бүр гэрээ байгуулан ажилладаг. Эмнэлгийн гаралтай хог хаягдлыг гэрээний дагуу өдөр бүр хүлээлгэн өгдөг.

НЯРАЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХАЛДВАР ХАМГААЛЛЫН БАЙДАЛ

ӨРГӨӨ АМАРЖИХ

Хэвийн төрөлтөөр төрсөн нярай болон мэс заслаар төрсөн нярайд тусд нь дархлаажуулсанаар халдвар хамгааллын дэглэмтэй холбоотой урвал хүндрэл гарахаас урьдчилан сэргийлж байна.



ХҮРЭЭ АМАРЖИХ

Нярайн тасагт дархлаажуулалтын өрөө гарган тохижуулан дархлаажуулалтын урвал хүндрэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.



АМГАЛАН АМАРЖИХ

Дархлаажуулалтын нэг өрөөтэй дархлаажуулалтын дараах урвал хүндрэлээс урьдчилан сэргийлж, халдвар хамгаалалын дэглэмийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

НЯН СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ

ӨРГӨӨ АМАРЖИХ

Нян судлалын лаборатортой.

Хэсэг, нэгж бүр шинжилгээний сорьц тээвэрлэх савтай

Зөөврийн болон өсгөврийн тэжээл болох пептон ус, сабор шөл, шар буурцгийн шөл зэрэг сонгомол тэжээлт орчинг бэлдэж эхлэн үйл ажиллагаанд хэрэглэсэн нь оношилгооны чадварыг нэмэгдүүлсэн.



ХҮРЭЭ АМАРЖИХ

ЭМС-ын 2016.10.21-ний өдрийн А/93 тоот "Шинжилгээний сорьц зөөвөрлөх журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор шинжилгээний сорьц тээвэрлэх савыг шинэчлэн тус журмыг мөрдөн ажиллаж байна.

Нян судлалын шинжилгээг ХӨСҮТ-ийн нян судлалын лаборатороор гэрээний дагуу хийлгэн ажиллаж байна.

Орчны эрүүл зүйн шинжилгээг МХЕГ-ын лавалгаа лабораторт гэрээний дагуу тогтмол шинжлүүлдэг.



ЭТҮХХ 2016 ОНЫ БАЙДЛААР:

- Өргөө амаржих
- Хүрээ амаржих
- Амгалан амаржих



Тохиодол бүртгэгдээгүй байна.



ДҮГНЭЛТ

- Хүрээ болон Амгалан амаржих газрууд нь дезкамергүй.
- Хүрээ болон Амгалан амаржих газрууд цэвэрлэгээг уламжлалт аргаар хийж байна.
- Хүрээ амаржих этилийн хийн ариутгагч аппарат байхгүй.
- Хүрээ болон Амгалан амаржих газрууд нь мэс заслаар болон төрөх замаар төрсөн нярайг дархлаажуулах нэг өрөөтэй байна.
- Хүрээ болон Амгалан амаржих газрууд нь нян судлалын лабораторгүй тул шинжилгээг ХӨСҮТ болон МХЕГ-ын лавалгаа лабораторит шинжлүүлдэг байна.
- Өргөө амаржих газар нь эрүүл ахуй, халдвар хамгааллын орчин үеийн тоног төхөөрөмж нэвтрүүлэлт Хүрээ, Амгалан амаржих газруудаас илүү сайн байна.



Анхаарал хандуулсанд баярлалаа

